



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№95 /539/

2023.06.13

Цаг үе, үйл явдал

## ДАДЛАГА СУРГУУЛЬД 2900 ГАРУЙ ХҮН ОРОЛЦОЖ, ХАРИЛЦАН АЖИЛЛАГААГ ЖИГДРҮҮЛЛЭЭ

Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Шадар сайдын ажлын алба, Онцгой байдлын ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын тамгын газар хамтран "Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшиг тохиолдож "онц байдал" тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт стратегийн команд штабын сургуулийг энэ сарын 7-9-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Сургуулийн хаалтын ажиллагаанд Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан оролцож хэлсэн үгэндээ "Монгол орны нутаг дэвсгэрт 2022 онд 58266 газар хөдлөлт болж, үүнээс хүнд мэдрэгдэх хэмжээний буюу 3.5 магнитуд болон түүнээс дээш хүчтэй газар хөдлөлт 134, түүний дотор 5-5.9 магнитудын хүчтэй газар хөдлөлт 3 удаа болсон.

Энэ үзүүлэлтийг сүүлийн 10 жилийн хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт болсон газар хөдлөлтийн дундаж үзүүлэлттэй харьцуулахад нийт газар хөдлөлт 5.7, хүнд мэдрэгдэм газар хөдлөлт 6 дахин өссөн. Газар хөдлөлтийн давтамж нэмэгдэж байгаатай холбогдуулан Газар хөдлөлтийн гамшигын аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлыг хангахад мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааг улсын хэмжээнд уялдуулан зохицуулж, нэгдсэн удирдлагаар хангах чиг, үүрэг бүхий байнгын ажиллагаатай дэд



зөвлөл ажиллаж байна.

Мөн газар хөдлөлтийн гамшигын аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан "Гамшигын аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах журам", "Гамшигын үед нүүлгэн шилжүүлэх журам", "Гамшигын үед хүч хэрэгсэл дайчлан гаргах журам", 2017 оны 67 дугаар тогтоол "Газар хөдлөлтийн гамшигын аюулыг таниулах өдөр зохион байгуулах журам" зэрэг эрх зүйн орчин, зохицуулалт цөөнгүй бий. Гагцхүү хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, иргэдэд сурталчлан таниулах чиглэлээр төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал

юм.

Тиймээс иргэдийнхээ амь нас, эрүүл мэнд, төрийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангахад байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдуулах холбоог сайжруулахад энэхүү сэдэвт стратегийн команд штабын сургуулийн үр нөлөө, ач холбогдол өндөр байна гэдэгт итгэлтэй байн. Сургуульд оролцож хамтран ажилласан олон улсын байгууллага, хүмүүнлэгийн байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, хуулийн этгээдийн төлөөлөн оролцсон та бүхэнд баярлалаа" гэлээ. Дадлага сургуулийн хүрээнд зохион байгуулсан гамшигын аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага, сургуульд нийт 400 мянган гаруй

иргэн хамрагдлаа.

Мөн Баянгол, Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Хан-Уул, Баянзүрх дүүрэгт газар хөдлөлтийн дараах мэргэжлийн ангийн тактикийн үзүүлэх сургууль, Налайх, Сонгинохайрхан дүүрэгт хээрийн эмнэлгийг дэлгэж, байгууллага хоорондын уялдаа холбоог хангаж, харилцан уялдааг хангасан юм.

Дадлага сургуульд Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын онцгой комисс, гамшгаас хамгаалах 12 улсын алба, яам, агентлаг, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллага, НҮБ-ын суурин зохицуулагчийн ажлын алба, 12 хүмүүнлэгийн тусламжийн сектор, Дэлхийн зөн Монгол болон эрүүл мэндийн байгууллага, 21 аймаг, нийслэлийн 9-н дүүргийн нутгийн захиргааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг 2900 гаруй хүн оролцлоо.

Оролцогчид газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулах штабын дадлага хийж, гамшгаас хамгаалах албад, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааг жигдрүүлээ.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀ 32	☁ 9

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀ 35	☁ 25

### ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,435	3,442
EUR	3,695	3,715
CNY	482	485
RUB	41	41.40
JPY	24.90	25.05
KRW	2.63	2.65

### ЗУРХАЙ



2023.06.13 /МЯГМАР ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 26

**ЗУНЫ ТЭРГҮҮН УЛААГЧИН МОГОЙ САР ДӨРВӨН НОГООН МЭНГЭТЭЙ ХАРАГЧИН ТУУЛАЙ ӨДӨР**

Үс засуулбал:

ЖАРГАЛ ҮРГЭЛЖИД ИРНЭ НАРАН УРГАХ, ШИНГЭХ: 04.53-20.52

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, бурханы үйл, хувцас хийхэд сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун чих цангинавал үзэсгэлэн болох, зүүн нь бол үхэл болсныг сонсох, нохой уливал сонсголонтой үг сонсох, тагнай загатнавал гэр арвидах, бие татвал 1-2 хүн ирэх, хөл татвал гомдол аюул болно.

## ЗАЛУУ ОФИЦЕРУУД БАЙГАЛЬ ОРЧНОО ХАМГААЛАХ ҮЙЛСЭД УРИАЛЖ БАЙНА



Өнөөдөр Цагдаагийн ерөнхий газар болон Шүүх шинжилгээний ерөнхий газраас хамтран "Залуу офицер-Байгаль орчноо хамгаалъя" сэдэвт Туул гол, Богдхан уул орчмыг цэвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулж, Төрийн цэргийн болон хууль сахиулах 11 байгууллагын дэслэгчээс хошууч цолтой 35 хүртэлх насны 1000 гаруй залуу офицер оролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн ивээл ирэх 9 дүгээр сард зохион байгуулагдах "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын чуулган"-ыг угтан Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицеруудын манлайлах, мэргэжлээрээ бахархах, мэдлэг, ур чадвар, албандаа хандах хандлага, итгэл үнэмшлийг дээшлүүлэх, урам зоригийг нэмэгдүүлэх, хамтын нөхөрлөлийг бэхжүүлэх, тэдний нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор олон төрлийн үйл

ажиллагааг зохион байгуулж байгаа билээ. Чуулган угтсан ажлын хүрээнд зохион байгуулагдаж байгаа энэхүү үйл ажиллагаанд Батлан хамгаалах яамны харьяа байгууллагууд, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Төрийн цэргийн командлалууд болон Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн төлөөлөл 180 залуу офицер оролцож, Туул голын сав газар, иргэд ихээр цугладаг голын эрэг дагуух амралтын хэсгүүд зэрэг хариуцсан хэсгийнхээ хог хаягдлыг цэвэрлэсэн юм.

Байгаль орчноо хамгаалах үйлсэд нэгдсэн залуу офицерууд манлайлал энгийн зүйлээс эхэлдгийг өгүүлээд ард иргэдээ дор бүрнээ хичээхийг уриалж байлаа. Бид анги, байгууллага удирдан ирсэн албан тушаалтнуудаас сэтгэгдлийг нь сонслоо.

БХЯ-ны Хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн хошууч Б.Мөнхбат "Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын залуу офицерууд бусдыг үлгэрлэн манлайлахын жишээ байх болно" гэсэн бол Шүүх

шинжилгээний ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн дарга цагдаагийн хошууч Б.Билгүүн "Чуулганыг угтан зохион байгуулж байгаа манай гурав дахь том арга хэмжээ ийнхүү амжилттай болж байна. Богд хан уулын дархан цаазат газар, Туул голын сав газар, иргэд ихээр цугладаг голын эрэг дагуух амралтын цэгүүд залуу офицеруудын маань хүчээр сайхан боллоо" гэлээ.

ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа К.Нямдаваа "Хүн бүр байгальдаа ээлтэй амьдралын дадал хэвшлийг бий болгох, байгалиа хамгаалах, эх оронч үзлийг хүн ардад түгээн дэлгэрүүлэх, төлөвшүүлэхэд залуу офицерууд уриалж, түүчээлэх ёстой. Энэ утгаараа энд хуран чуулсан мянган сайхан залуусын үйл хэрэг, үлгэрлэлийг ард иргэд үргэлжлүүлж,

санаа аваасай гэж хүсэж байна. Үндсэн хуульдаа хүртэл байгалиа хамгаалах нь хүний журамт үүрэг гэж заасан улс орны ард иргэн бүр дор дороо хичээж, үүргээ биелүүлээсэй гэж уриалж байна. Цагдаагийн экологийн алба нь хүн ардын байгал орчноо хамгаалахад уриалж, нийгмийн хариуцлага, экологийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр олон талт үйл ажиллагаа зохион байгуулдаг.

Өнөөдөр байгал хамгаалах үйлсэд бүх төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагийнхан нэгдэж, түүчээлж оролцож байгаад талархаж, бас бахархаж байна. Монголын ард түмэндээ залуу офицеруудынхаа түүчээлсэн байгалаа хамгаалах, хайрлах, цэвэрлэх энэхүү аяныг дор бүрнээ өрнүүлээсэй, үргэлжлүүлээсэй, идэвхтэй оролцоосой гэж хүсэж байна" гэж уриалж байна.



### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,295,159

Эдгэрсэн

Нийт: 662,751,851

Нас барсан

Нийт: 6,890,598

Цахим шууданд

# 30 ГАРУЙ ТҮРҮҮЧ, БАЙЛДАГЧ НИЙГЭМД ЭРЭЛТТЭЙ МЭРГЭЖЛЭЭР СУРАЛЦАЖ ТӨГСЛӨӨ



Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 014 дүгээр анги Батлан хамгаалахын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан тушаалын хүрээнд нийслэлийн Налайх дүүргийн Политехникийн коллежтой хамтран ажиллаж байгаа билээ. Энэ нь хугацаат цэргийн алба хаагчдыг алба хаах хугацаанд нь хувь хүний хөгжлийг дэмжих, мэргэжил эзэмшүүлэх зорилготой бөгөөд 30 гаруй түрүүч, байлдагч нарыг "Хүнд

машин механизмын оператор", "Замчин" гэсэн мэргэжлээр 1 жилийн хугацаатай мэргэжлийн үнэмлэх олгох сургалтад амжилттай сургаж, төгсгөлөө. Зургаадугаар сарын 13-ны энэ өдөр төгсөгчдөд мэргэжлийн үнэмлэх гардуулах "Эрдмийн баяр"-ын ёслол зохион байгуулагдаж, төгсөгчдийн ар гэрийнхэн болон ХЗЦК-ын Сургалт бэлтгэлийн хэлтсийн дарга хурандаа Т.Тогмиддүүмий, Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагч хурандаа

Г.Эрдэнэбаатар, Налайх Политехникийн коллежийн захирал С.Мөнхбат, тус коллежийн эрдэмтэн багш нар оролцлоо.

Инженерийн цэрэгт хугацаат цэргийн алба хаангаа мэргэжил эзэмшсэн дайчдад ангийн захирагч хурандаа Г.Эрдэнэбаатар баяр хүргэж хэлсэн үгэндээ "Та бүхэн өөрсдөөрөө бахархах эрхтэйг баярын энэ өдөр дарга нь хэлмээр байна. Эх орныхоо өмнө хүлээсэн үүргээ хүлээж, хугацаат цэргийн албаа нэр төртэй хааж байна. Тэгэхдээ бүр албаа хаангаа нийгэмд хамгийн эрэлт хэрэгцээтэй мэргэжлүүдээр суралцаж, үнэмлэхээ гардан авлаа. Халагдсаныхаа дараа эх орныхоо хаана ч очиж мэргэжлээрээ ажиллах бүрэн боломжтой. Эр цэргийн алба тэсвэр хатуужилтай, эр зоригтой, эх оронч үзэл хүмүүжилтэй болгоод зогсохгүй нийгэмд хэрэгцээтэй мэргэжлээр боловсролын байгууллагатай хамтран суралцуулж байгаа нь хэнд ч олдоод байдаггүй том боломж билээ. Сургалтыг хамтран зохион байгуулсан Налайх дүүргийн Политехникийн коллежийн удирдлага, эрдэмтэн хамт олонд баярлалаа" гэсэн юм.

Мөн тус коллежийн захирал С.Мөнхбат төгсөгчид сурах хүсэл тэмүүлэл өндөр, идэвх чармайлт сайн байсныг тодотгож, эзэмшсэн мэргэжлээрээ гялалзаж явахыг захилаа.

Үүний дараа түрүүч, байлдагч нарын ар гэрийн төлөөлөлд ангийн үйл ажиллагааг танилцуулж, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлсэн хэд хэдэн соёл хүмүүжлийн ажлыг зохион байгуулсан юм.

Хошууч Э.ХАШЦАХИУР

# ХЭЭРИЙН ГАРАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын "Ахлагчийг хөгжүүлэх төв"-ийг түшиглэн мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалт өнгөрсөн сард Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд эхэлсэн билээ. Сургалтад ахлагч болох хүсэлтэй илэрхийлсэн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудын 200 гаруй цэргийн гэрээт болон хугацаат албаны дайчид хамрагдаж байгаа бөгөөд энэ хугацаанд цэргийн сургалт бэлтгэл тасралтгүй явагдаж байна.

Тухайлбал, тавдугаар сарын 29-ний өдрөөс зургаадугаар сарын 12-ны өдөр хүртэл Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн Сургалтын төвийн районд хэргийн гаралтыг амжилттай зохион байгууллаа. Энэ үеэр мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтын хэргийн төвийг зохион байгуулж, 7 хоногийн хугацаатай эрчимжүүлсэн сургалт дадлага, буудлагын дасгалуудыг боловсруулж, тусгай тактикийн бэлтгэлийн 30 км явган марш болон хэргийн сургуулийг явуулав.

Хэргийн сургуулиар тактик, тусгай тактик, үй олноор хөнөөх зэвсгийн

хөнөөлөөс хамгаалах бэлтгэл, цэргийн байр зүй, амьд гарах арга ухаан, байрлалын хамгаалалт зэрэг хичээлийн цэгүүдэд үүрэг гүйцэтгэж, бэлтгэлжилтийн түвшингээ дээшлүүлж чадсан юм.

Сургалтын явцад алба хаагчдынхаа идэвх оролцоог нэмэгдүүлэх, нөхөрсөг харилцааг бэхжүүлэх, тэргүүний түрүүч, байлдагчаа урамшуулахад чиглэсэн олон арга хэмжээ явуулсан нь үр дүнтэй ажил байв. Тодруулбал, буудлагын дасгалын үеэр цэц мэргэнээрээ шалгарсан 10 цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийг "Онц буудагч" тэмдгээр шагнаж, хамт олонд нь үлгэр дуурайлал үзүүлэхийн зэрэгцээ "Fun Day" хөгжөөнт тэмцээн, "Бүжгийн үдэш"-ийг зохион байгуулсан нь нэгнээ танихгүй байсан анги ангийн дайчдын нөхөрсөг уур амьсгалыг улам бэхжүүлэв. Ийнхүү зургаадугаар сарын 12-ны өдөр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн байрлалд шилжин ирснээр хэргийн дадлага амжилттай өндөрлөсөн юм.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



# МӨНГӨН ХОНХНЫ БАЯРЫН ӨДРӨӨРӨӨ ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 110 ДУГААР АНГИАР ЗОЧИЛЛОО



Зэвсэгт хүчний 110 дугаар анги Орхон аймгийн ерөнхий боловсролын 13 дугаар сургуулийн төгсөх ангийн 90 гаруй сурагчдад цэрэг-эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор "Залуу үе-Эх орны ирээдүй" сэдэвт сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгууллаа.

Тус үйл ажиллагааны үеэр хүрэлцэн ирсэн хүүхэд, залууст зэвсэглэл,

химийн багаж хэрэгслийг дэлгэн танилцуулсны зэрэгцээ ангийн офицер, ахлагчийн бие бүрэлдэхүүн гардан тулааны үзүүлэх тоглолтоо толилуулсан юм.



# АЛСЛАГДСАН САЛБАНУУДАД ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГ ҮРГЭЛЖИЛЖ БАЙНА

Зэвсэгт хүчний Агаарын цэргийн командлагчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг баруун болон зүүн бүсэд байрлах анги, тусгай салбаруудад Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит Ёс зүй, бие бялдрын түвшин тогтоох үзлэгийг явуулж байна.

Тодруулбал, энэ сарын 12-ны өдөр хурандаа Ч.Буянзаяагаар ахлуулсан ажлын хэсэг Зэвсэгт хүчний 325 дугаар ангид үзлэгийг удирдамжийн дагуу алба хаагчдаас "Цэргийн нийтлэг дүрэм"-ээр шалгалт авч, ёс зүй болон сэтгэл зүйн бэлтгэлжилтийг нийгэм-сэтгэл зүйн чиглэлээр боловсруулсан дөрвөн төрлийн асуумж, хамт олны үнэлгээгээр тодорхойлж, бие бялдарын бэлтгэлжилтийн түвшинг "Цэргийн биеийн тамирын бэлтгэлийн стандарт"-ын дагуу хурд, хүч, тэсвэр, тусгай бэлтгэл, уян хатан гэсэн үзүүлэлтээр шалгаж байгаа юм. Мөн цэргийн алба хаагчдын жагсаалч байдлыг жагсаалын үзлэг явуулах замаар шалгаж, давхар дүрэмт хувцасны хэрэглээнд үнэлгээ хийж байна.

Ажлын хэсгүүд өдрөөр үзлэгээ зохион байгуулж шөнөөр хөдөлгөөн үйлдэн дараагийн салбарт хүрч өртөөлөн явсаар Монгол Улсын баруун урд хязгаарт хүрч тус ангийн харьяа Ховд аймгийн Булган суманд байрлах 305 дугаар тусгай ротод ирж жагсаалын үзлэгээр өнөөдрийн ажлаа эхлүүлж байна. Үзлэгийг бүх салбараас ижил үзүүлэлтээр авч, ил тодоор дүгнэн нээлттэй явуулж байгаа юм.



Мөн энэ цаг үед удамт хурдан хүлгүүдийн босоо цагаан хийморь ивээсэн наран мандах нутагт буюу Сүхбаатар аймгийн Баяндэлгэр суманд Агаарын цэргийн командлагчийн тушаалаар томилогдсон ажлын хэсэг зорин очсон байна. Энэ орон нутагт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн харьяа 085 дугаар тусгай рот эх орныхоо амгалан тайвны төлөө агаарын

хилийн дархан манаанд үүрэг гүйцэтгэдэг юм.

Тусгай ротуудын бие бүрэлдэхүүн ёс зүй, бие бялдарын бэлтгэлжилтийн үзлэгт бэлэн мөн агаарын хил тайван байгааг илтгэж байна.

Баруун болон зүүн бүсээр хоёрдугаар шатны үзлэг үргэлжилсээр...

Ахмад Л.САРАНЗАЯА

# ОРОН НУТГИЙН СУРАГЧДАД ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛСИЙГ СУРТАЛЧИЛЛАА



Энэ жил 50 жилийнхээ түүхийг бичиж байгаа Зэвсэгт хүчний 167 дугаар ангийнхан орон нутагтаа иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, цэрэг-эх оронч үзэл хүмүүжлийг түгээх, алба хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг сайжруулах хүрээнд 50 гаруй бүтээлч ажил санаачлан хэрэгжүүлж байна.

Түүхт ойгоо угтсан бүтээлч ажилд алба хаагч бүр хичээл зүтгэл дүүрэн оролцож байгаа бөгөөд 6 дугаар сарын 5,6-ны өдрүүдэд Өмнөговь аймгийн Политехник коллеж болон Ерөнхий боловсролын I, II дугаар сургуулийн суралцагч нарт "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" өдөрлөгийг зохион байгууллаа.

Монгол Улсын Зэвсэгт хүчний энхийг сахиулах үйлс дэх оролцоог сурталчилсан энэхүү өдөрлөгийг зохион байгуулсан алба хаагчид мэдээлэл, сургалт явуулахын зэрэгцээ оюутан сурагчдын идэвх оролцоог нь нэмэгдүүлэх үүднээс уралдаан тэмцээн өрнүүлэв.

"Миний аав энхийг сахиулагч" гар зургийн уралдаанд аймгийн

Политехникийн коллежийн оюутнуудаас Б.Батбаясгалан, Н.Сэргэлэнбаатар, С.Сайханбаяр нар, сурагчдаас У.Нямзаяа, Э.Дашлүндэг, Э.Дашлүндэг болон А.Арсланбаатар, Н.Баяр, Г.Санчир нар тэргүүллээ.

Арга хэмжээний төгсгөлд дэслэгч Д.Золзаяа, ахлах ахлагч Ө.Сэр-Од нар "Хэнгэрэг дэлхийн цэрэг", "Энхийн цэргүүд дуулж байна", "Дэлхийд данстай Монгол цэрэг" дуугаар мэндчилгээ өргөж, өдөрлөгийг чимэв.

